

СҮХБААТАР АЙМГИЙН СОЁЛ УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ГАЗРЫН 2024 ОНЫ III УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Сүхбаатар аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, Соёлын тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журмын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчтай 2024 онд 7 зорилт, 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулан III улирлын байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 93.5%-тай хэрэгжиж байна. Монгол Улсын Соёлын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/04 дүгээр тушаалаар батлагдсан “Аймгийн Соёл, урлагийн газрын дүрэм”-д заасны дагуу харьяа 15 байгууллагыг мэргэжил аргазүйн удирдлагаар хангаж, аймгийн Засаг даргад соёл, урлагийн чиглэлээр шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Хүний нөөц, нийгмийн баталгааг хангах, дэмжлэг үзүүлэх чиглэлээр:

Монгол Улсын Соёлын сайдын 2022 оны А/04 дүгээр тушаалаар Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь 12 орон тоотой батлагдсанаас одоогийн байдлаар 9 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Төрийн албаны зөвлөлийн Сүхбаатар аймаг дахь салбар зөвлөлд төрийн захиргааны 2 албан тушаалын сул орон тооны захиалгыг хүргүүлж төрийн жинхэнэ албаны тусгай шалгалтыг зарлуулсан боловч орон тоо нөхөгдөөгүй байна.

2024 оны III улирлын байдлаар аймгийн соёл, урлагийн 15 байгууллагад 205 албан хаагч ажиллаж байгаагийн 114 эмэгтэй бөгөөд энэ нь нийт ажиллагчдын 55.6 хувь, мэргэжлийн ажиллагчид 85 бөгөөд энэ нь нийт ажиллагчдын 41.4 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд соёл, урлагийн салбарын 5 байгууллагын 9 ажилтанд орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн тэтгэмжид 69.3 сая төгрөг батлагдсан байна. 2023 онд салбарын хэмжээнд үр дүнд суурилсан санхүүжилтээр 157.9 сая төгрөгийн санхүүжилт авч байсан бол 2024 онд 193.9 сая төгрөгийн санхүүжилт авч өмнөх онтой харьцуулахад 1.2%-ээр өссөн үзүүлэлттэй байна.

2024 оны III дугаар улирлын байдлаар соёл, урлагийн салбарт улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр 724.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн. Тухайлбал, Соёлын яамны хөрөнгө оруулалтаар Соёл, урлагийн газарт фургон автомашин, сийлбэртэй 8 ханатай гэр, суурин компьютерийн шинэчлэлд 96.2 сая төгрөг, Баяндэлгэр, Уулбаян, Түмэнцогт, Эрдэнэцагаан сумын соёлын төвд 152.0 сая төгрөгийн лед дэлгэц, Сүхбаатар сумын соёлын төвийн орон нутаг судлах музейн засварт 332.0 сая төгрөг, Түмэнцогт сумын соёлын төвийн дээврийн засварт 47,590.0 мянган төгрөг, Онгон сумын соёлын төвийн барилгын зураг төсөвт 17.0 сая төгрөг, Уулбаян сумын соёлын төвийн урлагийн хувцас шинэчлэлд 15.0 сая төгрөг, Эрдэнэцагаан сумын соёлын төвийн гадна пасад засварт 60.0, Түвшинширээ сумын соёлын төвийн тайзны гэрэл 5.0 сая

төгрөгийг тус тус шийдвэрлэсэн. Эдгээр ажлуудыг хэрэгжүүлсний үр дүнд салбарын албан хаагчдын ажиллах орчин нөхцөл сайжирч, ажилчдын нийгмийн асуудал шийдвэрлэгдэж байна.

2.2 Төсөв, санхүү, шилэн дансны чиглэлээр: Соёл, урлагийн газрын хэмжээнд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, Төрийн аудитын газрын 2023 оны хяналт шалгалтаар өөрчлөлтгүй дүгнэгдсэн байна.

Соёл, урлагийн газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах удирдамжийн дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд явцын хяналт хийх ажиллахад, 2024 оны хагас жилийн байдлаар байгууллагын шилэн дансанд нийт 171 мэдээлэл, үүнээс эхний хагас жилд нийт 78 мэдээлэл байршуулахаас хугацаандаа: тухай бүр 45, сар бүр 19, жил бүр 4 мэдээллийг мэдээлсэн байна. Харин 2 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлснийг цаашид давтан гаргахгүй байх талаар нягтлан бодогчид зөвлөмж өгч ажиллалаа.

2.3 Албан хаагчдыг чадавхжуулах сургалтын чиглэлээр: Соёл, урлагийн газрын 2024 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу байгууллагын албан хаагчдыг чадавхижуулах чиглэлээр салбарын болон бусад, дотоодын сургалтуудад цахим, танхим хосолсон хэлбэрээр давхардсан тоогоор 118 албан хаагчийг хамруулсан бол байгууллагаас иргэд, олон нийт рүү чиглэсэн “Үндэсний нэгдмэл үнэт зүйл” сэдэвт соён гэгээрүүлэх сургалтад 127 хүнийг тус тус хамруулж мэдлэгийг нь дээшлүүлж ажиллалаа.

Тайлант хугацаанд Удирдлагын академийн Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт, төрийн захиргааны ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын дунд хугацааны эрх сунгах болон тасралтгүй боловсрол олгох сургалт, Удирдлагын академийн төрийн албан хаагчдад зориулсан (монгол бичиг, хүний эрх, ёсзүй, авлига) цахим сургалт, Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалт болон байгууллагын дотоод сургалтаар архив, албан хэрэг хөтлөлт, угийн бичиг, жендэрийн сургалтуудыг зохион байгуулж албан хаагчдыг чадавхжуулж ажиллалаа.

2.4 Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр: Тайлант хугацаанд 4 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, 5 албан хаагчийн ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд шинэчлэн гаргуулж, холбогдох тайланг Соёлын яамны ЭБАТ-д цаг хугацаанд нь хүргүүлж ажиллалаа. Мөн Соёл, урлагийн газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/04 дүгээр тушаалаар Соёл, урлагийн газрын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 13 заалттай батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд 2024 оны хагас жилийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 90%-тай байна.

Тайлант хугацаанд Авлигатай тэмцэх газар, Соёлын яамны 3 удаагийн сургалтад танхим, цахим хэлбэрээр хамрагдаж байгууллагын 12 албан хаагч, салбарын 15 удирдах албан тушаалтанд цахимаар мэдээлэл хүргэж ажилласан. Мөн Удирдлагын академийн төрийн албан хаагчдад зориулсан “Авлигаас ангид төрийн алба” сэдэвт 1-3 дугаар түвшний 12 цагийн цахим сургалтад байгууллагын

6 албан хаагч хамрагдаж, авлига, ашиг сонирхлын талаар мэдлэгээ дээшлүүлж ажиллалаа.

2.5 Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр: 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн байдлаар Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газраас холбогдох дээд байгууллага, албан тушаалтанд хандаж 225 албан бичиг, байгууллагын даргын 59 тушаалыг кирилл болон үндэсний хос бичгээр гарган албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу үйлдсэн байна.

Байгууллагын 2024 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан дагуу архив, бичиг хэргийн ажилтныг Архивын ерөнхий газрын “Баримт бичгийн стандарт, баримт бичгийн зохион бүрдүүлэх арга зүй” (Г-24/289) сэдэвт 1.5 кредит цагийн мэргэшүүлэх сургалтад байгууллагын захиалгаар сургаж, архив, бичиг хэргийн ажилтныг компьютерт монгол бичгээр бичих ур чадварыг нь нэмэгдүүлэх зорилгоор ажлын байран дээр сургалтад хамруулж байна.

Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийг <https://erp.e-mongolia.mn/> үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлэн ашиглалтыг сайжруулах талаар соёл, урлагийн салбар 15 байгууллагын архив, бичиг хэрэг хариуцсан 30 албан хаагчдад цахимаар сургалт зохион байгуулж, онлайнаар бичиг хэрэг, албан даалгавар, тушаал шийдвэрүүдийг нэг эх үүсвэрээс өгч, авч, цаг бүртгэлд цахимаар хяналт тавин, ажил хэрэг, албан бичиг, хүний нөөцийн мэдээллийн баяжилтыг тухай бүр мэдээллийн санд оруулж хэвшсэн.

2.6 Соёлын салбарын статистик мэдээллийн чиглэлээр: Тайлант хугацаанд 2023 оны жилийн эцсийн хөрөнгө санхүүгийн мэдээ, үйл ажиллагааны мэдээ болон улирлын мэдээ тайланг соёл, урлагийн салбарын 15 байгууллагаас хүлээн авч нэгтгэлийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газарт тогтоосон цаг хугацаанд нь маягтын дагуу гаргаж хүргүүлсэн. 2022 онд салбарын хөрөнгө санхүүгийн нийт орлого 5,939,258 мян төгрөг байсан бол 2023 онд 5,969,157 мян төгрөг буюу 29,899 мян төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Санхүүжилт 2022 оныхоос 1,519,703 мян буюу 71,5%-аар, салбарын ажил үйлчилгээний нийт орлого 2022 оноос 37,868 мян буюу 69 %-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Аймгийн 12 соёлын төвд 363 урлагийн тоглолт, 1573 соёл олон нийтийн бусад арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна. 2024 оны I улирлын статистик мэдээгээр • Урлагийн тоглолт-24, зохион байгуулсан соёл, олон нийтийн ажил-31, урлагийн тоглолтын үзэгч-5528, үүнээс хүүхэд-1511, соёл, олон нийтийн ажилд оролцогсод-10318, номын сангийн уншигч-4060 байна. Соёлын салбарын статистик мэдээ гаргахад анхаарах асуудлаар Соёл, урлагийн газрын 2024 оны 02 дугаар сарын 29-ны өдрийн 73 дугаар албан бичгээр соёлын салбарын харъяа 15 байгууллагад 9 заалттай зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Салбарын 15 байгууллагын үйл ажиллагаанд зөвлөн туслах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ байгууллагын удирдлага, статистик мэдээ хариуцан ажилладаг 15 байгууллагын 30 албан хаагчдад газар дээр нь зөвлөгөө зөвлөмж өгч ажиллан, анхан шатны бүртгэлийн дэвтрийг үнэн, бодитой хөтлөх талаар мэргэжил, аргазүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

2.7 Салбар байгууллагуудын үйл ажиллагаанд зөвлөн туслах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиглэлээр: Соёл, урлагийн газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн баталсан удирдамжийн дагуу Соёл, урлагийн газрын ажлын хэсгийн бүрэлдэхүүн салбар 15 байгууллагын үйл ажиллагаанд зөвлөн туслах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Зөвлөн туслах ажлын хүрээнд соёлын салбарын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлагналт, удирдлага зохион байгуулалт, хүний нөөц, төсөв санхүү, соёлын олон талт үйл ажиллагаа зэрэг шаардлагатай баримт бичгийг хянан үзэж мэргэжил аргазүйн удирдлагаар хангаж ажиллалаа. Цаашид зөвлөн туслах ажлын хүрээнд илэрсэн нийтлэг зөрчил, дутагдлыг арилгахаар харьяа 15 байгууллагуудад хугацаатай үүрэг даалгаврыг хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

2.8 Жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр: Соёл, урлагийн газрын 2024 оны жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны 6 заалттай төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд 2024 оны II улирлын байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 90%-тай байна. Тайлант хугацаанд удирдлагын академийн төрийн албан хаагчдад зориулсан хүний эрхийн 1-3 дугаар түвшний 12 цагийн цахим сургалтад 7, Аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулсан “Жендэрийн тухай ойлголт” танхимын сургалтад 10 албан хаагч тус тус хамрагдаж, жендэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх талаар ойлголт, мэдлэгээ дээшлүүлсэн байна.

Соёл, урлагийн газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/08 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 1.1, 2.3.10, 5.8.3, 5.8.4, 5.8.6, 5.8.7-д хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байран дахь бэлгийн дарамтын асуудлаар санал гомдол хүлээн авах, шийдвэрлэх талаар холбогдох заалтыг шинээр тусган хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Жендэрийн үндэсний хорооноос “Харилцан хүндэтгэе” аяныг 2024.03.01-ний өдрөөс 1 сарын хугацаанд үндэсний хэмжээнд зохион байгуулсан бөгөөд тус аянд Сүхбаатар аймгийн соёл, урлагийн салбарын 16 байгууллагын 191 албан хаагчид нэгдэж, байгууллагын пэйж хуудсаараа олон нийтэд сурталчилж ажиллалаа.

2.9 Байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр: Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулахын тулд нийтдээ 52 мэдээ мэдээллийг Сүхбаатар аймгийн Соёл, урлагийн газар пэйж хуудсаар, Соёлын яамны мэдээллийг 26 удаа шейр (хуваалцсан) хийж түгээсэн байна. Тайлант хугацаанд байгууллагын бодлого, үйл ажиллагааны талаар телевизийн 3 захиалгат нэвтрүүлэг, 2 контентыг бэлтгэж, 12 удаагийн ярилцлагыг өгч, байгууллагын пэйж хуудас, олон нийтийн мэдээллийн сүлжээнд байршуулан иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан байна.

Тайлант хугацаанд төрийн албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хос бичгээр хөтлөн явуулахтай холбогдуулан байгууллагын пэйж хуудсанд 15 удаагийн мэдээллийг кирилл болон үндэсний хос бичгээр бэлтгэж хүргэсэн байна.

2.10 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр: Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 350 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газраас тогтоосон, байгууллагын эзэмшил газарт 110 ширхэг хайлаас модыг шинээр тарьж, цэнэг усалгааг хийн холбогдох байгууллагад тайланг хүргүүлж ажиллалаа.

2.11 Салбарын удирдах ажилтнуудыг мэдээллээр хангах чиглэлээр: Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын ээлжит цахим хуралд байгууллагын удирдлага тухай бүр оролцож, салбар байгууллагуудын удирдах албан тушаалтнуудыг цаг үеийн мэдээллээр хангаж үүрэг чиглэл өгч ажиллаж байна. Тайлант хугацаанд Сүхбаатар аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газраас салбар 15 байгууллагын удирдлагуудтай сар бүрийн 1-ний өдөр цахим шуурхай хурал хийж хэвшсэн бөгөөд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг танилцуулж салбар байгууллагуудын тухайн сард хэрэгжүүлсэн ажлын тайланг сонсож, харилцан бие биеэсээ туршлага судлан ажиллаж байна.

ГУРАВ. СОЁЛ, ГЭГЭЭРЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

3.1 Үндэсний бичиг, соёлын жилийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын талаар:

Монгол Улсын Монгол хэлний тухай хуульд 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжих бэлтгэлийг бүрэн хангах зорилтыг дэвшүүлсэн. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийн зорилт Сүхбаатар аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, түүний харьяа 15 байгууллагуудад амжилттай хэрэгжиж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлиг, Соёлын яамны стратеги төлөвлөгөөний 4.2, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эх хэл, бичиг, түүх, соёлын дурсгалаа судлах, хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, бүх нийтийн монгол бичгийн хэрэглээг дээшлүүлэх, үндэсний бичгээ сэргээн хэрэглэх төрийн бодлогын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар дараах ажлуудыг зохион байгуулж, хэрэгжүүллээ. Үүнд:

3.1.1 Салбар байгууллагуудад албан хэргийг хос бичгээр нэвтрүүлэх ажлын хүрээнд: Соёл, урлагийн газрын даргаар ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2024 онд салбарын 15 байгууллагад зөвлөн туслахдаа Монгол хэлний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ын 3.3.5, 3.3.7 дахь заалтын хэрэгжилтийг шалгаж, ажил эрчимжүүлэх чиглэлээр хугацаатай зөвлөмж хүргүүлсний үр дүнд салбарын 11 байгууллага буюу 68.7% нь албан бичгийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах ажлыг тогтмолжуулж, салбарын хэмжээнд 100% “Үндэсний бичгийн уншлагын цаг”-тай болсон бодит үр дүн гарсан. Цаашид “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага” MNS 6395:2022

стандартын дагуу албан хэргээ хос бичгээр хөтлөн турших ажлыг эрчимжүүлж, захирамжлалын болон албан бичгийг хос бичгээр тогтмол гаргаж хэвших талаар салбар байгууллагуудад үүрэг чиглэл өгч ажиллаж байна.

3.1.2 Цахим хуудас, нэрийн хуудас, хаягжуулалт: Тайлант хугацаанд Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь байгууллагын үйл ажиллагааны онцлох мэдээ, мэдээллийг албан ёсны цахим хуудаст үндэсний бичгээр хөтлөн хос бичигтэн байгууллага болох зорилт тавин ажиллаж байна. 2024 оны 09 дүгээр сарын байдлаар 15 мэдээллийг кирилл болон үндэсний хос бичгээр бэлтгэж олон нийтэд сурталчлан ажилласан. Мөн байгууллагын 10 албан хаагчдын нэрийн хуудас болон албан байгууллагын хаягжилтийг монгол бичгээр хийлгэсэн.

3.1.3 Үндэсний бичгийн чадавхжуулах сургалт: Соёл, урлагийн газрын 2024 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Монгол Улсын гавьяат багш Ш.Чулуунбортой сургалтын гэрээ байгуулж, байгууллагын 10 албан хаагчийг монгол бичгийн 30 цагийн танхимын сургалтад хамруулан төлбөрт 480.000 төгрөгийг зарцуулсан. Мөн Насан туршийн боловсролын төвтэй хамтран байгууллагын албан хаагчдад үндэсний бичгээр зурагт хуудас бэлтгэх сургалт болон “Үндэсний бичгийн кимо хөрвүүлэгч ашиглах арга зүй” сэдэвт танхимын сургалтуудыг хамтран зохион байгууллаа. Сургалтын үр дүнд албан хаагчид канва программыг ашиглан өөрсдийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах мэдээлэл, постерийг үндэсний бичгээр бэлтгэж байгууллагын пэйж хуудсаар олон нийтэд түгээн дэлгэрүүлж сурсан бодит үр дүн гарсан байна.

Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэдэх Удирдлагын академийн төрийн албан хаагчдад зориулсан Монгол бичгийн 1-3 дугаар түвшний 40 цагийн цахим сургалтад байгууллагын 9 албан хаагчид 100% хамрагдаж гэрчилгээ авсан байна.

“Бүх нийтийн соёлын боловсролын хөтөлбөр”-ийн хүрээнд Жаахан шарга театраас Дорнод аймгийн багш нартай хамтран Үндэсний бичгийн уран бичлэгийн танхимын сургалтыг зохион байгуулсан бөгөөд Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын мэргэжилтэн Э.Ундармаа уран бичлэгийн төлбөрт сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан.

Удирдах албан тушаалтан “Уламжлалт бичиг-Удирдлагын манлайлал” сургалтад байгууллагын дарга тогтмол хамрагдаж, Сүхбаатар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 31 байгууллагын удирдлагуудад “Монгол бичиг урлал” сэдвээр 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хичээлийг бие даан явуулж, сургалт хийсэн.

3.1.4 “Хүмүүн бичиг” сонин захиалж, үйл ажиллагааны мэдээллээ хэвлүүлсэн байдал: Тайлант хугацаанд үндэсний долоо хоног тутмын “Хүмүүн бичиг” сонинг Соёл, урлагийн газрын 10 албан хаагчид тогтмол захиалж, үндэсний бичгээр уншиж, бичих ур чадвараа дээшлүүлж байна.

Соёл, урлагийн газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн “Үндэсний бичгийн уншлагын өдөртэй болох тухай” А/21 дүгээр тушаалаар Соёл,

урлагийн газрын хэмжээнд долоо хоног бүрийн Пүрэв гаригийн 16:00-17:00 цагийг үндэсний бичгийн уншлагын цаг болгож, үндэсний бичгээ уншиж хэвшсэн.

“Хүмүүн бичиг” сонины 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн №13 (1371) дугаарын “Хүмүүн бичигтэн” хамт олон буланд Сүхбаатар аймгийн Соёл, урлагийн газраас үндэсний бичгийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл бэлтгэн нийтлүүлж орон даяар байгууллагын үйл ажиллагааг сурталчлан ажилласан. Соёл, урлагийн газраас үндэсний бичгийг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр хийгдсэн онцлог ажлуудаа “Хүмүүн бичиг” сонин, Монцамэ агентлаг, орон нутгийн SBINFO сайт болон салбар байгууллагууд өөрийн албан ёсны цахим хуудсуудаар мэдээ, мэдээллийг олон нийтэд сурталчлан сум, орон нутаг дахь бусад төрийн байгууллагуудаа уриалж манлайлан ажиллаж байна.

Мөн соёл, урлагийн салбарын харьяа 15 байгууллагуудад “Хүмүүн бичиг” сонинг захиалан унших талаар чиглэл хүргүүлж ажилласнаар салбарын хэмжээнд хүмүүн бичиг сонинг 100% захиалж, байгууллага бүр долоо хоногийн тогтмол цагт уншлагын цагтай болсон зэрэг бодит үр дүн гарсан.

3.1.5 Салбарын албан хаагчдын монгол бичгийн түвшин тогтоох сорил: Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 вебинар сургалтаар зохион байгуулагдсан үндэсний бичгийн сургалтад салбарын албан хаагчдыг тогтмол хамруулж байна. Мөн Үндэсний статистикийн хороо, Хэлний бодлогын үндэсний зөвлөл хамтран зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа”-нд салбар 15 байгууллагын 200 албан хаагчийг 100% бүрэн хамруулсан.

Тайлант хугацаанд соёл, урлагийн салбарын албан хаагчдын үндэсний бичгийн түвшин тогтоох сорилыг салбарын хэмжээнд хоёрдахь жилдээ зохион байгуулсан. Салбарын 16 байгууллагын 204 албан хаагчдын “Монгол бичгийн мэдлэгийн түвшин тогтоох” ажлыг аймгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, одоогийн байдлаар 129 албан хаагчид буюу 63.2%-ийг түвшин тогтоох сорилд хамрууллаа. Сорилын дүнгээс харахад салбарын албан хаагчдын унших чадвар 52.6%, бичих чадвар 39.7%-тай байна. Сорилын үр дүнтэй холбогдуулан аймгийн соёл, урлагийн салбарын удирдах ажилтны цахим шуурхай хурлаар 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд албан хаагчдыг мэдлэгийн түвшинд тохируулж үндэсний бичгийн анхан, дунд шатны сургалтад хамруулах, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт арга хэмжээний шалгуур үзүүлэлт болгож албан хаагчдын ажлыг үнэлж дүгнэх талаар үүрэг чиглэл өгч ажиллалаа.

3.1.6 Сүхбаатар аймгийн Засаг даргын Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн “Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай” албан даалгаврын хэрэгжилт: “Хос бичигтэн байгууллага” уралдааны хэрэгжилтэд явцын хяналт хийх хуваарийн дагуу аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 31 байгууллагад ажиллаж, нэгдсэн мэдээллийг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Даваа гаригийн удирдах ажилтны шуурхай хурал дээр танилцуулсан. Мөн Соёл, урлагийн газрын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 152 дугаар албан бичгээр аймгийн хэлний бодлогын зөвлөлд албан даалгаврын хэрэгжилтийн тайланг хүргүүлсэн.

3.1.7 Нөлөөллийн ажлууд: Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдааны 44 дүгээр тэмдэглэлд 2024 оныг соёлын салбарын хэмжээнд “Үндэсний бичиг, соёлын жил” болгон зарласантай холбогдуулан салбар байгууллагуудын дунд “Хос бичигтэн байгууллага”, “Уран бичлэг”-ийн уралдааныг тус тус зарлаж, тэргүүлсэн байгууллага, албан хаагчдыг Соёл, урлагийн ажилтны баярын өдрөөр шагнаж урамшууллаа.

Соёл, урлагийн газраас бүх нийтийг соён гэгээрүүлэх зорилгоор үндэсний бичиг үсэг, соёлын өвийг эрхэмлэн дээдлэгч бүх шатны төрийн байгууллагуудын дунд 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл 1 сарын хугацаанд зарласан “Үндэсний бичиг” контент бүтээх уралдаанд Нийгмийн даатгалын газрын хамт олон тэргүүн байр эзэлж, Соёл, урлагийн газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/30 дугаар тушаалаар мөнгөн шагналаар шагнагдсан. Тус үйл ажиллагааг байгууллагын пэйж хуудсаар олон нийтэд сурталчлан ажиллалаа.

Монгол Улсын Соёлын яамнаас 2024 оныг “Үндэсний бичиг, соёлын жил” болгон зарласантай холбогдуулан Монгол үндэсний бичиг үсгийн тиг, зурлага, уран бичвэрийн гайхамшгийг сурталчлан таниулах, түүх, соёл, бичгийн ухааныг гар урлалын бүтээлд амилуулах, хойч үедээ өвлүүлэн үлдээх, тэдний сурах, судлах эрмэлзлийг төрүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн VI-XII дугаар ангийн сурагчдын дунд “Үсэг урлалд амилахуй” уралдааны I шатыг аймгийн хэмжээнд 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 09-ний өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулж аймгаас шалгарсан бүтээлийг “Үсэг урлалд амилахуй-2024” улсын уралдаанд оролцуулсан. Улсын уралдаанаас Түмэнцогт сумын ЕБС-ийн 12б ангийн сурагч Э.Эмүжингийн “Газар нутаг” торгон дээрх хатгамал тусгай байрын шагнал хүртсэн байна.

Сүхбаатар аймгийн Соёл, урлагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хамтран баталсан удирдамжийн дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, чадварыг сорих, эх хэлний боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 05 дугаар сарын 23-ны өдөр “Цэвэр сайхан бичигтэн”, “Хурдан уншлагын тэмцээн”-ийг тус тус зохион байгуулж, тэргүүлсэн алба хаагчдыг шагнаж урамшуулан бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж, хамтын ажиллагаагаа өргөжүүлсэн.

3.1.8 Бусад үйл ажиллагааны чиглэлээр: Аймгийн Засаг даргын тамгын газар, Насан туршийн боловсрол төв, Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газар, “Аригун арт” галлерей хамтран зохион байгуулсан нэрт сэтгүүлч, яруу найрагч Ишийн Батсүхийн нэрэмжит “Жаахан шаргын нутаг-2024” монгол бичгийн уралдааны үзгийн хичээнгүй бичгийн төрөлд байгууллагын 10 албан хаагчид хамрагдсан. Тус уралдаан нь энэ жилийн хувьд зүүн бүсийн хэмжээнд зохион байгуулагдснаараа онцлогтой бөгөөд үзгийн хичээнгүй бичгийн төрөлд соёл, урлагийн салбарын 7 байгууллага оролцсоноос “Жаахан шарга театр” гуравдугаар байр эзэлсэн байна. Уралдааны 30 шилдэг бүтээлээр аймгийн Угсаатны зүйн

музейд “Хүмүүн бичиг” үзэсгэлэн 14 хоног дэлгэгдэж, олон нийтийн хүртээл болсон.

Үндэсний 35 дахь “Номын баяр”-ыг угтаж аймгийн Нийтийн номын сангаас зохион байгуулсан “Үндэсний бичиг”-ийн “Аварга уншигч” уралдаанд Соёл, урлагийн газрын 3, Жаахан шарга театрын 3 албан хаагч тус тус оролцсоноос “Жаахан шарга театр”-ын ажилтан тэргүүн байр эзэлсэн бол бусад оролцогчид өнгөрсөн жилийн амжилтаа ахиулсан байна. Тус уралдаанд ерөнхий боловсролын сургуулийн 7-9 дүгээр ангийн ангилалд 115, 10-12 дугаар ангийн ангилалд 35 сурагч, Насанд хүрэгсдийн ангилалд 14 буюу нийтдээ 164 хүн оролцож, оролцогчдын тоо өмнөх оноос 20 хувиар өссөн байна. Мөн “Аварга уншигч” уралдаанд Халзан, Мөнххаан, Онгон, Сүхбаатар сумдаас оролцсон нь онцлог байлаа.

3.2 Утга зохиолоор дамжуулан иргэдийг соён гэгээрүүлэх талаар:

МЗЭ-ын Сүхбаатар аймаг дахь салбартай хамтран сар бүрийн 17-ны өдөр “Яруу увдис” арга хэмжээг тогтмол хамтран зохион байгуулж байна. “Үндэсний бичиг үсгийн баяр”-т зориулж Сүхбаатар аймгийн Дарьганга сумын харьяат, яруу найрагч Б.Төгсжаргал болон үндэсний 35, 36 дахь “Номын баяр”-ыг угтаж Сүхбаатар аймгийн харьяат “Их бага Баян Шарга” ТББ-ын тэргүүн Л.Бор, яруу найрагч Т.Эрдэнэцогтын “Зохиолч-Уншигчийн уулзалт”-уудыг аймгийн Нийтийн номын сан, Уулбаян сумын Соёлын төвтэй тус тус хамтран зохион байгуулсан.

2024 онд Сүхбаатар аймгийн МЗЭ-ийн салбар үүсгэн байгуулагдсаны 70 жилийн ой тохиож буйтай холбоотой Баруун-Уртад үйлдвэрлэсэн, хүүхэд залуусын сэтгэхүйг хөгжүүлэх зорилгоор тус салбараас буддаг хүүхэлдэйн барималыг гаргасан. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл /Утга зохиол, ном хэвлэл/-д МЗЭ-ийн гишүүн О.Одхүүгийн “Хайрлахын заяа”, “Их бага Баян Шарга” ТББ-ын тэргүүн Л.Борын “Шаргын шаргал уулаа хайрлан хамгаалахын учир”, Ш.Чулуунборын “Жавхлантшарга Сүхбаатар аймгийн анхдагчид” зэрэг номын нээлтүүдээ хийсэн. Үндэсний 35 дахь “Номын баяр”-ыг тохиолдуулан Онгон сумын Соёлын төв “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн танхим”-ыг тохижуулан өв тээгч болон иргэдэд үзүүлж сонирхуулсан.

3.3 Бүх нийтийн соёлын боловсролын хөтөлбөрийн талаар:

Соёл, урлагийн байгууллагуудад “Бүх нийтийн соёлын боловсрол”-ын хөтөлбөр боловсруулахад Соёл, урлагийн газраас “Зөвлөн туслах” ажлын хүрээнд танхимаар арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Үүний үр дүнд салбарын 4 байгууллага “Бүх нийтийн соёлын боловсролын хөтөлбөр”-ийг боловсруулж баталсан. Үүнд: Соёл, урлагийн газарт 2, Угсаатны зүйн музейд 4 боловсролын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн байна. Сумдын Соёлын төвүүд, Угсаатны зүйн музейд “Дарьганга марзай”, “Үлгэрч сүхбаатарчууд”, “Хүн чулуун хөрөг”, “Гэр”, “Янзага”, “Өөшхөө” зэрэг боловсролын хөтөлбөр хэрэгжиж, нийтдээ 1402 хүн хамрагдсан.

“Бүх нийтийн соёлын боловсрол хөтөлбөр”-ийн хүрээнд Соёл, урлагийн газрын дэргэдэх Ахмадын зөвлөлийн тэргүүн Г.Энхцэцэгийн санаачлагаар

Аймгийн засаг даргын ивээл дор “Үлгэрч Сүхбаатарчууд” төсөл хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн. Уг арга хэмжээ нь “Үлгэрч өвөө эмээ”, “Үлгэрч аав ээж”, “Үлгэрч ах эгч” гэсэн ангиллаар 3 үе шаттай явагдаж, ангилал тус бүрээс эхний 3 байрыг шалгаруулсан. Тус уралдаанд 9 сумын 16 үлгэрч оролцож, авьяас чадвараа сорьсон байна.

3.4 Угийн бичиг хөтлөлтийг нэмэгдүүлэх чиглэлээр: “Үндэсний өв соёлыг дээдлэн дэлгэрүүлэгч” ерөнхий боловсролын 2 дугаар сургуультай хамтран 12 дугаар үе буюу 11 дүгээр ангийн суралцагчид 2 жилийн турш “Угийн бичиг”-ийг нийт хүүхдүүдийн 70 хувь нь амжилттай хөтөлж, үзэсгэлэн гарган, шилдэг хүүхдүүдээ шалгарууллаа. Соёл, урлагийн газраас “Бүх нийтийн соёлын боловсрол”-ын хөтөлбөрт “Угийн бичиг”-ийг дэд хөтөлбөр болгон баталсантай холбоотой “Угийн бичиг”-ийн сургалтыг зохион байгуулж, байгууллагын бүх албан хаагчид хамрагдаж, “Угийн бичиг” хөтөлж эхэлсэн. Мөн аймгийн “Насан туршийн боловсролын төв”-тэй хамтран “Угийн бичиг”-ийн хамтарсан төлөвлөгөөг баталсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1991 оны 115 дугаар зарлиг, Засгийн газрын 2007 оны 257 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Соёл, урлагийн газар, Гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газартай хамтран албан байгууллага, аж ахуй нэгжийн албан хаагчдын угийн бичиг хөтлөлтийг нэмэгдүүлэх, өвлүүлэн уламжлуулах түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Угийн бичиг – Удмын хэлхээ” аяныг 2024 оны 09-р сарын 04 – 2024.10.04-ний өдрүүдэд зохион байгуулж, шилдэг угийн бичиг хөтөлсөн албан хаагчдыг шагнаж урамшуулах ажил хүлээгдэж байна.

ДӨРӨВ. УРЛАГ, УРАН БҮТЭЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Тайлант хугацаанд “Жаахан шарга театр”-аас “Домгийн хатираа” этник концертыг шинээр туурвиж Асгат, Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Онгон сумдад тоглож, 1565 хүнд хүрч үйлчилснээс 1155 буюу 74.0%-ийг хүүхэд эзэлж байна. Мөн тус бүтээлийг Багануур, Говьсүмбэр, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын үзэгчдэд тус тус тоглосон. Дээрх уран бүтээлд Жаахан шарга театр болон орон нутгийн төсвөөс 3.0 сая төгрөгийн төсөв зарцуулагдсан ба Соёл, урлагийн газраас бүх талын дэмжлэг үзүүлсэн. Тус театраас угсаатны онцлогт суурилсан түүхэн жүжгийг 2024 оны 11 дүгээр сард туурвихаар төлөвлөж, цомнол зохиолыг бичүүлж байна.

“Жаахан шарга театр”, орон нутгийн хэвлэл мэдээллийн BBS телевизтэй хамтран цагийн үеийн нөхцөл байдал, зудын хүнд үед байгаа иргэдэд зориулж “Дэм дэмэндээ” теле концертыг бүтээж, цахим орчим болон өргөн нэвтрүүлгийн сувгаар түгээсэн. Уг бүтээл нь давхардсан тоогоор 13150 хүн буюу нийт хүн амын 19,9 хувьд хүрсэн. Мөн Жаахан шарга театрын хөгжимчин, морин хуурч Чойжилсүрэн, хөгжимчин, ятгачин Сэвжидмаа нарыг МҮОНРТ-ийн цагаан сарын баярт зориулан бэлтгэдэг “Монгол түмний мэнд” нэвтрүүлэгт оролцуулж, уран бүтээлчдийн бүтээлийг олон нийтэд хүргэхэд дэмжлэг үзүүлсэн.

“Жаахан шарга театр”-ын Уран сайхны удирдаач З.Далайгийн найруулга “Гэгээн муза-11” олон улсын наадмын шилдэг бүтээл “Муурын байшин” мюзикл жүжгийг Асгат, Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Онгон сумдад тоглож, Жаахан

шарга театрын ерөнхий найруулагчийн бүтээл ахлах ангийн сурагчдад зориулсан “Ромео үхэх ёсгүй” хүүхдийн оролцоот драмын жүжгийг шинээр туурвиж нийт 1291 хүүхдэд хүрсэн нь үзэгч хүүхдийн тоо өмнөх оны жилийн эцсээс 50 хувиар нэмэгдсэн байна.

Соёл, урлагийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар хамтран “Үсэг урлалд амилахуй” уран бичлэг, бүтээлийн уралдаан, “Хүүхдийн ертөнц” гар зургийн уралдаан, “Би эстрадын дуучин” гоцлол дууны уралдаан, “Хүрэл тулга” яруу найргийн уралдаануудын 1, 2 дугаар шатыг аймагтаа зохион байгуулж, тэргүүн байр эзэлсэн хүүхдүүдийн бүтээлүүдийг улсын уралдаанд оролцуулж дэмжлэг үзүүлсэн. “Би эстрадын дуучин” уралдаанд цэцэрлэгийн болон ахлах насны ангилал тус бүрд Гранпри шагнал, “Хүрэл тулга” уралдаанд дунд насны ангилалд тусгай байр, “Үсэг урлалд амилахуй” уралдаанд тусгай байр, “Хүүхдийн ертөнц” уралдаанд цэцэрлэг, дунд, ахлах насны ангилал тус бүрт тусгай байр эзэлсэн амжилт үзүүлсэн.

ТАВ. СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР

Улс, аймгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх 31 дурсгалын хадгалалт хамгаалалтыг иргэн, хуулийн этгээдэд гэрээгээр хариуцуулах ажлын хүрээнд 2022 онд шинэчлэн батлагдсан маягтын дагуу 2-3 жилийн хугацаатайгаар гэрээг шинэчлэн байгуулсан гэрээний хугацаа дуусах болоогүй, хяналт тавин ажиллаж байна.

Иргэд, сүм хийдэд хадгалагдаж байгаа 76 (Уулбаян-1, Эрдэнэцагаан-1, Халзан-8, Баяндэлгэр-2, Сүхбаатар-42, Дарьганга-22 ном судар, ил захидал, сонингын хайчилбар) баримтат өвийг бүртгэлд хамруулсан.

2024 онд Соёл, урлагийн газраас соёлын биет бус өвлөн уламжлагч нарыг сурталчилах, олон нийтэд таниулах зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран цуврал нэвтрүүлэг, контент, ярилцлага зэрэг олон арга хэлбэрээр мэдээ мэдээлэл бэлтгэн олон нийтэд хүргэж байна. Тухайлбал, SBINFO сайтын “Сод өв” контентод Уулбаян сумын соёлын биет бус өвлөн уламжлагч Дарьганга уртын болон богино дуу дуулаач Н.Лувсанцэрэн, малын гаралтай түүхий эдээр гар урлал урлаач Г.Дэнсмаа нар, BBS телевизийн “Уудалж баршгүй-Соёлын өв” нэвтрүүлэгт Баруун-Урт сумын өвлөн уламжлагч Дарьганга дархан Ж.Уранбилэг, Н.Амартайван нар, “Сүхбаатарын өнгө сонин”-д Түмэнцогт сумын соёлын биет бус өвлөн уламжлагч Д.Дондог, Тэргүүний ардын авъяастан Г.Эрдэнэчулуун нарыг ярилцлагаар өгүүлж олон нийтэд сурталчлан ажилласан байна.

СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ГАЗАР